




MONGOLIAN CASHMERE



ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ
ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН
-2019-



АГУУЛГА

- 02-04** КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА
Бүтэц зохион байгуулалт
- 05-10** БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
Онцлох үйл явдлууд
Үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн шинэ технологи, хөгжүүлэлт
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт
Шинэ коллекциуд
- 11-17** САНХҮҮГИЙН ТАЙЛАН
Санхүү, үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд
Санхүүгийн тайлан
Их хэмжээний хэлцэл
Сонирхлын зөрчилтэй хэлцэл
Санхүүжилтийн мэдээлэл
Компанийн удирдлагын зардал
- 18-19** ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА
Хувьцааны арилжаа
Ногдол ашиг
- 20-30** КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ
Засаглалын тогтолцоо
Хувьцаа эзэмшигчид
Хувьцаа эзэмшигчдийн хурал
Төлөөлөн удирдах зөвлөл
Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
Эрх бүхий албан тушаалтнууд
Тогтвортой хөгжил
Нийгмийн хариуцлагын тайлан



КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Компанийн оноосон нэр	Говь Хувьцаат Компани
Үйл ажиллагааны чиглэл	Ямааны ноолууранд цогц боловсруулалт хийж, бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах
Компанийн албан ёсны хаяг	Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК Шуудангийн хаяг: Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг 36/434, Говь ХК Утас: (976)-70139977 Факс: (976)-70143081 И-мэйл: info@gobi.mn Вэб сайт: www.gobi.mn Фэйсбүүк: GobiCashmere Онлайн дэлгүүр: www.gobicashmere.com
Компанийн удирдлага	ТУЗ-ийн дарга: Дамбын ГЭРЭЛМАА Гүйцэтгэх захирал: Цагаачийн БААТАРСАЙХАН
Үүсгэн байгуулагдсан огноо	1981 оны 9 сарын 5-ны өдөр
Ажилтнуудын тоо	2,712
Хүчин чадал	1,200 тонн түүхий ноолуур боловсруулах 800 тонн ээрмэл утас, 30 тонн нарийн ээрмэл утас хийх 1,500,000 ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 1,100,000 метр нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх 162,000 ширхэг ноолууран пальто, пиджак, хослол үйлдвэрлэх
Дэлгүүрийн тоо	Дотоод Улаанбаатар хот 6 Дархан хот 1 Гадаад Салбар дэлгүүр 5 Франчайз дэлгүүр 61

ЭРХЭМ ЗОРИЛГО

Говь ХК нь хүний хөгжил, технологиор тэргүүлэн, хэрэглэгч, харилцагчдын сэтгэл ханамжийг хамгийн өндөрт хүргэж, хөрөнгө оруулагч, ажилтнуудын үнэ цэнэтэй байгууллага байна.

ЭРХЭМЛЭХ ҮНЭТ ЗҮЙЛС

- Компанийхаа төлөө зүрх сэтгэл, бүхий л авьяас чадвараа дайчлан ажиллаж буй чадварлаг мэргэжилтэн, ажилтнууд
- Бидэнтэй үргэлж хамт байдаг нийт хэрэглэгч, харилцагч, бизнесийн түншүүд
- Дэлхийд хосгүй Монгол ноолуур
- Дэлхийн дэвшилтэт технологийн үйлдвэр

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ


- Шударга, ил тод, нээлттэй
- Хууль, дүрмийг чандлан сахиулна
- Хүний эрхийг дээдэлнэ
- Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ
- Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулна

УРИА ҮГ

Дэлхийд танигдсан Монгол брэнд



БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД



МОНГОЛДОО АНХ УДАА 100% НООЛУУРАН НИМГЭН ДААВУУГААР ХОСЛОЛ ХИЙЖ ЭХЭЛЛЭЭ

1 сард Монголын ноос ноолуурын салбарт шинэчлэлт хийж, хамгийн анхны 100% ноолууран нимгэн даавуун эрэгтэй хослолыг худалдаанд гаргасан.



ХОНКОНГ-Д ФРАНЧАЙЗ ДЭЛГҮҮРЭЭ НЭЭЛЭЭ

1 сард БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс болох Хонконг-д шинэ франчайз дэлгүүрийн нээлтийг хийсэн.



САН ФРАНЦИСКО ХОТОД ФРАНЧАЙЗ ДЭЛГҮҮРЭЭ НЭЭЛЭЭ

2 сард АНУ-ын Сан Франциско хотод шинэ франчайз дэлгүүрийн нээлтийг хийсэн.



“MADE TO MEASURE” ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2 сард шинэхэн бүтээсэн 100% ноолууран нарийн нимгэн даавуу болон түүгээр урласан эрэгтэй хослолыг танилцуулах арга хэмжээ зохион байгуулагдсан. Уригдан ирсэн хүндэт зочиддоо хамгийн анхны 100% ноолууран нарийн нимгэн даавуун хослолыг зөвхөн өөрийн биед тааруулан хувь захиалгаар хийлгэх боломжийг олгосон.





ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

4 сарын 18-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг компанийн Төв дэлгүүрийн дэргэдэх “Мираж” ресторанд зохион байгууллаа. Хуралд нийт 691,528,080 саналын эрхтэй 285 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирж, хурлын ирц 88.64% байв.



ГОВЬ ХК-ИЙГ “ТОП-100” АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭГЭЭР ӨРГӨМЖИЛЛӨӨ

2019 оны 5 сарын 16-ны өдөр Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “ТОП-100” Аж Ахуйн Нэгжийг шалгаруулах ёслол болж, Говь ХК нь 18 дугаар байранд шалгарлаа.



ДЭЛХИЙД ТАНИГДСАН МОНГОЛ БРЭНД УРИАН ДОР ГОВЬ ХК, ГОЁО ХХК НЭГДЛЭЭ

2019 оны 5 сарын 29-ний Говь ХК-ийн ТУЗ-ийн №12 тогтоолоор Говь ХК нь Гоёо ХХК-ийн нийт хувьцааг худалдан авсан бөгөөд Гоёо ХХК нь 100% Говь ХК-ийн охин компани болсон.



ГОВЬ БОЛОН ГОЁО-ЫН ХАМГИЙН ТОМ НООЛУУРАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЯМДРАЛЫН ДЭЛГҮҮР НЭЭГДЛЭЭ

6 сард Гоёо ХХК-ийн үйлдвэрийн дэргэдэх дэлгүүрийг Gobi, Goyo, Yama, Gobi Organic, Gobi Kids брэндүүдийн хамгийн өргөн сонголт бүхий Ноолууран Бүтээгдэхүүний Хямдралын Дэлгүүр болгон дахин нээсэн.



НООЛУУРАН ПАЛЬТО БОЛОН ХОСЛОЛЫН ХАМГИЙН ТОМ ТАСАГ "ГАЛЛЕРИА УЛААНБААТАР" САЛБАРТ НЭЭГДЛЭЭ

6 сард Галлериа Улаанбаатар дэлгүүрийн тасгийн өөрчлөлт зохион байгуулалтыг хийж, зөвхөн ноолууран пальто болон хослолын тасгийг нээн, хэрэглэгч нарт илүү тав тухыг мэдрүүлж чадсан.



100% НООЛУУРАН НАРИЙН НИМГЭН ДААВУУГААР ХҮЧИРХЭГ ШИЙДЭМГИЙ ТӨРХИЙГ ТОДОТГОСОН ЭМЭГТЭЙ ХОСЛОЛЫГ ХУДАЛДААНД ГАРГАЛАА

6 сард эмэгтэй хэрэглэгч нартаа зориулан 100% ноолууран нарын нимгэн даавуугаар сонгодог, классик хослолуудыг урлан худалдаанд гаргасан.



ГОВЬ БРЭНДИЙН ХОСЛОЛ "PITTI UOMO" ҮЗЭСГЭЛЭНГ ЧИМЛЭЭ

6 сард эрэгтэй хувцасны чиг хандлага, трэндийг тодорхойлогч "PITTI IMAGINE UOMO" үзэсгэлэн Италийн Флоренц хотод 96 дахь удаагаа зохион байгуулагдсан. Энэхүү үзэсгэлэнд Говь брэнд оролцож, хослол, өнгө, загвар, чанараараа "PITTI IMAGINE UOMO" үзэсгэлэнгийн мэргэжилтнүүдийн нүдэнд өртөж, Монголын хувцас загварын хөгжлийг шинэ түвшинд гаргаж чадсан.



ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛСЭН ШИНЭ ТЕХНОЛОГИ, ХӨГЖҮҮЛЭЛТ

ОЁМОЛЫН ҮЙЛДВЭР



Шулуун оёдлын автомат машин

Шинээр үйлдвэрлэж буй хослолын чанар, өнгө үзэмжийг сайжруулахын тулд:

“Juki” үйлдвэрийн хамгийн сүүлийн үеийн автомат шулуун оёдлын машин 11 ширхэгийг суурилуулан ашиглаж байна. Ингэснээр хослолын оёдлын чанар сайжирсан.



Өмдний алхам пресс

Өмдний бүсний пресс

Туркийн Малкан ХХК-ийн эцсийн хэлбэржүүлэгч пресс машиныг суурилуулан ашигласнаар хослолын хэлбэр суултны чанар сайжирсан.



Өмдний түдүүл бэлтгэх машин

СҮЛЖМЭЛИЙН ҮЙЛДВЭР



Хэрээслэж хаддаг товчны машиныг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр 1ш товчийг гараар 50 секундэд хаддаг байсан бол машинаар 15 секундэд хаддаг болж нэгж хугацаа багассан.

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН



100% НООЛУУРАН НАРИЙН
ДААВУУН НИМГЭН ЭРЭГТЭЙ
ХОСЛОЛ



ЦУВНЫ КОЛЛЕКЦ



ХАТГАМАЛТАЙ ПИДЖАК




100% НООЛУУРАН НАРИЙН
ДААВУН НИМГЭН ЭМЭГТЭЙ
ХОСЛОЛ



ШИНЭ КОЛЛЕКЦИУД

ҮНДСЭН КОЛЛЕКЦ



ХАВАР/ЗУН 2019



ОРГАНИК ХАВАР/ЗУН 2019



YAMA ХАВАР/ЗУН 2019



НААДАМ 2019

НЭМЭЛТ КОЛЛЕКЦ



"ХАТАД" ПРИНТТЭЙ
ШААЛЬ



"БАЙГАЛЬ"
БАРЛАСАН ШААЛЬ



"IRIS" СИЛКТЭЙ
КОЛЛЕКЦ



ДАНИ УЛСЫН БАЛЛЕТЧИДТЭЙ
ХАМТАРСАН ШИНЭ ШААЛЬ

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2019.06.30			2018.06.30 гүйцэтгэл	Өмнөх оноос өсөлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт		тоо	хувь
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	сая.төг	81,468	68,308	84%	55,648	12,660	23%
Дотоод борлуулалт	сая.төг	53,970	44,743	83%	36,486	8,257	23%
Гадаад борлуулалт	сая.төг	27,499	23,565	86%	19,162	4,403	23%
БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ	сая.төг	46,673	45,032	96%	32,780	12,252	37%
НИЙТ АШИГ	сая.төг	34,796	23,276	67%	22,868	408	2%
Үйл ажиллагааны зардал	сая.төг	22,802	19,030	83%	14,617	4,413	30%
Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	2,341	1,749	75%	2,554	-806	-32%
Татварын өмнөх ашиг	сая.төг	9,653	2,497	26%	5,697	-3,200	-56%
ЦЭВЭР АШИГ	сая.төг	7,240	1,715	24%	4,417	-2,702	-61%
Цэвэр ашгийн хувь	хувь	9%	3%	28%	8%	0	-68%
Экспорт	мян.USD	10,000	8,882	89%	7,907	975	12%
Нийт үйл ажиллагааны зардал	сая.төг	69,475	64,062	92%	47,397	16,665	35%
Орлогын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	0.85	0.94	110%	0.85	0.09	10%
ҮЙЛДВЭРЛЭЛТ							
Сүлжмэл	ширхэг	425,881	412,704	97%	345,809	66,895	19%
Нэхмэл	метр	232,740	209,706	90%	293,162	-83,456	-28%
Оёмол	ширхэг	44,690	43,195	97%	37,566	5,629	15%
Үүнээс: Пальто	ширхэг	32,929	26,939	82%	26,972	-33	0%
Ээрмэл	тонн	150	128	85%	189	-61	-32%
ТҮҮХИЙ ЭД БЭЛТГЭЛ							
Ноолуур	тонн	611	415	68%	762	-347	-46%
АЖИЛТНУУДЫН ТОО	хүн	2,712	2,712	100%	2,006	706	35%
Нэг ажилтанд ногдох орлого	мян.төг	30,040	25,187	84%	27,741	(2,553)	-9%
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	сая.төг	4,740	4,476	94%	11,233	(6,757)	-60%




ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Цэвэр ашиг
1.7
тэрбум төг



Төлсөн татвар
13.7
тэрбум төг



Хөрөнгө оруулалт
4.5
тэрбум төг

ДОТООД ЗАХ ЗЭЭЛ



Дотоод борлуулалт
44.7
тэрбум төг



Дотоод зах зээлд эзлэх %
82%



Салбар дэлгүүр
7

ГАДААД ЗАХ ЗЭЭЛ



Экспорт
23.6
Тэрбум.төг



Гадаад зах зээлд эзлэх %
79%

13 орны 40 хотод
Салбар дэлгүүр **5**
Франчайз дэлгүүр **60**

ҮЙЛДВЭРЛЭЛТ



Сүлжмэл
413
мян. шир



Нэхмэл
210
мян. метр



Оёмол
43
мян. шир

ХҮНИЙ НӨӨЦ



Ажилтнуудын тоо
2,712



Эрэгтэй
24%
Эмэгтэй
76%



Захиргаа
333
Борлуулалт
315
Үйлдвэр
2,064

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2019 оны 6 сарын 30
(мян. төг)

ҮЗҮҮЛЭЛТ	2018.12.31	2019.06.30
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,940,940	3,993,220
Дансны ба бусад авлага	12,183,569	14,342,178
Урьдчилгаа төлбөр	4,690,681	12,047,801
Бараа материал	142,538,944	243,158,448
Буцаах эрхтэй бараагаарх хөрөнгө	268,017	-
	164,622,151	273,541,647
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	82,380,060	123,142,733
Хойшлогдсон татварын хөрөнгө	1,250,554	1,986,615
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	355,697	697,967
	83,986,311	125,827,316
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	248,608,462	399,368,963
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны ба бусад өглөг	4,741,052	53,764,455
Орлогын албан татварын өглөг	1,755,234	18,119
Буцаах эрхтэй банкны өр төлбөр	466,329	-
Гэрээний өр төлбөр	1,037,239	3,832,139
Богино хугацаат банкны зээл	113,722,628	170,613,357
	121,722,482	228,228,071
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөр	3,231,805	8,062,520
Урт хугацаат банкны зээл	6,000,000	84,507,631
	9,231,805	92,570,151
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	130,954,287	320,798,222
Эзэмшигчдийн өмч		
Хувьцаат капитал	780,113	780,113
Дахин үнэлгээний нэмэгдэл	15,647,697	15,647,697
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	(135,203)	(129,972)
Хуримтлагдсан ашиг	101,361,568	62,272,903
	117,654,175	78,570,741
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	248,608,462	399,368,963



НЭГТГЭСЭН ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

2019 оны 6 сарын 30
(мян. төг)

ҮЗҮҮЛЭЛТ	2018.12.31	2019.06.30
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	173,439,375	68,307,919
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	(102,147,527)	(45,032,000)
НИЙТ АШИГ	71,291,848	23,275,919
Санхүүгийн ба бусад орлого	542,045	413,561
Бусад олз ба (гарз)	(6,561,605)	(1,534,815)
Хүүгийн зардал	(10,521,942)	(6,752,263)
Борлуулалт ба маркетингийн зардал	(20,210,195)	(9,148,092)
Ерөнхий ба удирдлагын зардал	(11,290,196)	(3,757,372)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	(1,523)	-
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ	23,248,432	2,496,938
Орлогын татварын зардал	(5,484,268)	(781,666)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН ЦЭВЭР АШИГ	17,764,164	1,715,272
ДАРАА ҮЕҮДЭД АШИГ, АЛДАГДАЛ РУУ АНГИЛАГДАХ БУСАД ИЖ БҮРЭН ОРЛОГО:		
Гадаад дахь охин компаниас үүссэн валют хөрвүүлэлтийн зөрүү	(106,929)	(129,972)
БУСАД ИЖ БҮРЭН (ЗАРЛАГА)/ОРЛОГО	(106,929)	(129,972)
НИЙТ ИЖ БҮРЭН ОРЛОГО	17,657,235	1,585,300

НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2019 оны 6 сарын 30
(мян. төг)

ҮЗҮҮЛЭЛТ	ХУВЬЦААТ КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭ НЭМЭГДЭЛ	ГАДААД ВАЛЮТЫН ХӨРВҮҮЛЭЛТИЙН Н НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН АШИГ	НИЙТ
2017.12.31 ҮЛДЭГДЭЛ	780,113	15,647,697	(28,274)	85,313,652	101,713,188
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	17,764,164	17,764,164
Бусад иж бүрэн орлого	-	-	(106,929)	-	(106,929)
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого	-	-	(106,929)	17,764,164	17,657,235
Зарласан ногдол ашиг	-	-	-	(1,716,248)	(1,716,248)
2018.12.31 ҮЛДЭГДЭЛ	780,113	15,647,697	(135,203)	101,361,568	117,654,175
Тайлант жилийн цэвэр ашиг	-	-	-	3,243,456	3,243,456
Бусад иж бүрэн орлого	-	-	5,231	-	5,231
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого	-	-	5,231	3,243,456	3,248,688
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	(37,027,357)	(37,027,357)
Зарласан ногдол ашиг	-	-	-	(5,304,765)	(5,304,765)
2019.06.30 ҮЛДЭГДЭЛ	780,113	15,647,697	(129,972)	62,272,903	78,570,741

НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2019 оны 6 сарын 30
(мян. төг)

ҮЗҮҮЛЭЛТ	2018.12.31	2019.06.30
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Тайлант жилийн цэвэр ашиг	17,764,164	1,715,272
Тохируулгууд:		
Элэгдэл ба хорогдлын зардал	6,558,878	5,558,920
Орлогын татварын зардал	5,484,268	781,666
Хүүгийн зардал	10,521,942	6,752,263
Хүүгийн орлого	(228,987)	(133,278)
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн алдагдал	5,394,904	940,603
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	1,523	58,667
Бараа материалын хасагдуулгын зардал/(буцаалт)	120,103	
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	181,707	144,954
Үндсэн хөрөнгө болон бараа материалыг бүртгэлээс хассанаас илүү давсан даатгалын нөхөн олговор	-	-
	45,798,502	15,819,065
Дансны ба бусад авлагын өсөлт	(1,146,933)	(2,500,879)
Урьдчилгаа төлбөрийн өсөлт	(1,564,247)	(7,357,120)
Бараа материалын өсөлт	(41,387,287)	(93,856,350)
Буцаах эрхтэй бараа материал өсөлт	(268,017)	
Дансны ба бусад өглөгийн өсөлт	439,989	49,023,403
Гэрээний өр төлбөр болон буцаах эрхтэй барааны өглөгийн бууралт	(134,913)	
	1,737,094	(38,871,881)
Төлсөн орлогын татвар	(6,867,067)	(2,368,459)
Төлсөн хүү	(9,444,335)	(7,180,612)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(14,574,308)	(48,420,953)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Хүлээн авсан хүүгийн орлого	228,987	5,637
Үндсэн хөрөнгө борлуулснаас орж ирсэн мөнгө	99,506	1,341,052
Даатгалын нөхөн олговроос орж ирсэн мөнгө	-	-
Худалдан авсан үндсэн хөрөнгө	(28,077,935)	(5,551,632)
Худалдан авсан бусад эргэлтийн бус хөрөнгө	(105,736)	(182,874)
Холбоотой талд өгсөн санхүүжилт	(3,000,314)	-
Холбоотой талд өгсөн санхүүжилтээс төлөгдсөн дүн	3,000,314	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(27,855,178)	(4,387,817)



САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Авсан зээл	186,137,535	138,930,195
Төлсөн зээл	(144,231,210)	(87,008,904)
Төлсөн ногдол ашиг	(1,717,781)	(60,241)
Холбоотой талуудаас авсан санхүүжилт	5,586,782	5,300,000
Холбоотой талуудаас авсан санхүүжилтэнд төлсөн дүн	(5,586,782)	(5,300,000)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	40,188,544	51,861,049
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл	(1,880)	0
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН (БУУРАЛТ)/ӨСӨЛТ	(2,242,822)	(947,720)
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	7,183,762	4,940,940
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	4,940,940	3,993,220

ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

Тайлангийн хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй.

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

Доорх холбоотой талуудтай хийсэн гүйлгээнүүд нь зах зээлийн нөхцлөөр хийгдсэн болно.

(мян. төг)

ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ	2019.06.30
Холбоотой талд өгсөн санхүүжилт	-
Холбоотой талаас авсан санхүүжилт	5,300,000
Холбоотой талтай хийсэн борлуулалт	2,736,399
Холбоотой талаас авсан худалдан авалт	1,079,061
Хүүгийн орлого	-
Хүүгийн зардал	84,351
Түрээсийн орлого	57,126
Түрээсийн зардал	95,435

САНХҮҮЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

(мян. төг)

БАНКНЫ НЭР	2018.12.31	2019.06.30	ЭЗЛЭХ ХУВЬ
Голомт Банк	6,343,008	75,748,958	30%
Худалдаа Хөгжлийн Банк	9,640,000	13,831,282	5%
Монгол Улсын Хөгжлийн Банк	53,143,360	82,080,000	32%
Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк	42,286,720	40,108,015	16%
Хас Банк	-	15,946,560	6%
Хаан Банк	-	19,258,251	8%
Азийн Хөгжлийн Банк	6,000,000	6,000,000	2%
САНХҮҮЖИЛТИЙН ДҮН	117,413,088	252,973,066	100%

КОМПАНИЙН УДИРДЛАГЫН ЗАРДАЛ


(мян. төг)

ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2018.06.30	2019.06.30
ТУЗ-ийн цалин урамшуулал	57,080	72,000
Удирдлагын цалин урамшуулал	345,068	267,656
Хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал	21,259	13,665
НИЙТ	423,407	353,321



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ БА КОМПАНИЙН ХУВЬЦАА

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА



ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

ҮЗҮҮЛЭЛТ	2019.06.30		2018.12.31	2018.06.30	
ГАРГАСАН ХУВЬЦААНЫ ТОО (шир)	780,112,500		780,112,500	7,801,125	
Төрөл	энгийн хувьцаа		энгийн хувьцаа	энгийн хувьцаа	
ХУВЬЦААНЫ ҮНЭ (төг)*	Өсөлт, бууралт /%/				
	2018.12.31-нээс				2018.06.30-наас
Хаалтын үнэ	294.31	11.9% ↓	22.5% ↑	333.89	240.20
Хамгийн их үнэ	354.11	4.3% ↓	28.1% ↑	369.77	276.40
Хамгийн бага үнэ	275.79	34.4% ↑	34.4% ↑	205.20	205.20
Дундаж үнэ	307.48	15.2% ↑	31.8% ↑	266.80	233.38
АРИЛЖААЛАГДСАН ТОО (шир)	4,694,166	148.8% ↑	7,207.6% ↑	1,886,927	64,237
АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН (мян. төг)	1,483,271	65.6% ↓	1.6% ↓	4,315,409	1,506,829
КОМПАНИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ (мян. төг)	229,594,910	11.9% ↓	22.5% ↑	260,471,763	187,383,022

* Говь ХК хувьцаагаа 100 хуваасантай холбоотой өмнөх хугацаан дахь хувьцааны бодит ханшийг 100 хуваасан ханш руу хөрвүүлж илэрхийлэв.

НОГДОЛ АШИГ

НОГДОЛ АШИГ ТАРААЛТЫН ТАЙЛАН

Ногдол ашиг зарласан он	Нэгж хувьцаанд зарласан ногдол ашиг (төг)	Нийт зарласан ногдол ашгийн дүн (мян. төг)	Ногдол ашиг тараалт
1996	61	475,869	Говь ХК 2007 онд хувьчлагдсан бөгөөд түүнээс өмнөх жилүүдэд зарласан ногдол ашгийг компани дээрээ тарааж байна.
1997	154	1,199,813	
1998	150	1,170,169	
1999	166	1,294,987	
2000	100	780,113	
2001	20	157,271	
2005	60	468,068	
2006	60	468,068	
2010	100	780,113	ҮЦТХТ-өөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлэх замаар 100% тараасан.
2011	100	780,113	
2012	125	975,141	
2013	130	1,014,146	
2014	140	1,092,158	
2015	140	1,092,158	
2016	200	1,560,225	
2017	220	1,716,247	
2018	6.8	5,304,765	2019 оны 4 сарын 25-ны өдрөөс тарааж эхэлсэн.

2018 ОНД ЗАРЛАСАН НОГДОЛ АШИГ, ТҮҮНИЙГ ТАРААХ ЖУРАМ

Говь ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 2 сарын 13-ны өдрийн хурлын №2 тогтоолоор 2018 оны санхүүгийн үр дүнгээс хувьцааны нэгж тутамд 6.8 төгрөг буюу нийт 5,304,765,000 төгрөгийг ногдол ашигт тараахаар шийдвэрлэсэн. Энэ нь өмнөх онтой харьцуулахад нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ 209% өссөн үзүүлэлттэй байв.


2018 оны ногдол ашгийг 2019 оны 4 сарын 25-ны өдрөөс эхлэн компани дээрээ тарааж, хувьцаа эзэмшигчдэд хүссэн үед нь бэлэн мөнгөөр эсвэл харилцах дансанд нь шилжүүлэх замаар чирэгдэл багатай арга хэлбэрээр саадгүй олгох бөгөөд 2019 оны эцэст ногдол ашгийн үлдэгдэл тооцоог гарган Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансанд нь шилжүүлэх болно.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦОО

Говь ХК-ийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчид, удирдлагууд болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлын тэнцвэрийг хангаж, компанийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, хэрэгжүүлэх, хянахад чиглэсэн бүтэц, зохицуулалтын нийлбэр юм.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага юм. Компани Хувьцаа эзэмшигчдийн хурлаараа Компанийн тухай хуулийн 62.1-т заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах болон ТУЗ-өөс эсвэл компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэхээр тогтоосон компанийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны гол асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

ЭЭЛЖИТ ХУРАЛ

Говь ХК Хувьцаа эзэмшигчдийнхээ ээлжит хурлыг 2019 оны 4 сарын 18-ны өдөр 691,528,080 саналын эрхтэй 285 хувьцаа эзэмшигч оролцож, 88.64 хувийн ирцтэйгээр хуралдан дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2018 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн “Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2018 онд төлөвлөгдсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан” гэсэн дүгнэлт өгснийг 99.96%-ийн саналаар батлав.
2. 2017 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2018 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулав.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргийг хэрэгжүүлдэг. ТУЗ-өөс жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг сар тутмын тайлангаар хянан, холбогдох үүрэг, чиглүүлгийг өгч ажиллаж байна. Мөн дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Эрсдэл аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороодыг байгуулж, компанийн засаглалыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, Эрсдэл аудитын хорооны удирдлага дор Дотоод аудитын хэлтсийг ажиллуулан компанийн хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Эрсдэл, аудитын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл, аудитын хорооны зорилго нь байгууллагын нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт, журмуудын нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдал, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих, хараат бус аудиторын мэргэжлийн үр чадвар, хараат бус байдлыг үнэлэх, сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Нэр дэвшүүлэх хороо

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

Цалин, урамшууллын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, бусад гүйцэтгэх удирдлагууд, эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллыг томъёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

2019 онд Төлөөлөн удирдах зөвлөл 10 удаа, Эрсдэл, аудитын хороо 1 удаа тус тус хуралдаж, холбогдох чиг үүргийн хүрээнд нийт 25 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэн, 18 тогтоол гарган, компанийн стратегийг тодорхойлж, үйл ажиллагааг чиглүүлэн, хяналт тавьж ажиллалаа.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ХАРААТ БУС ГИШҮҮД



**Дамбын
ГЭРЭЛМАА**

ТУЗ-ийн дарга
Хараат бус гишүүн

/Цалин урамшууллын
хорооны дарга, Нэр
дэвшүүлэх хорооны
гишүүн/

**СЭЗИС, Бизнес
удирдлагын
тэнхимийн
профессор**



**Мягмарын
БАЯР**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

/Нэр дэвшүүлэх
хорооны дарга/

**ШУТИС-ийн ҮТС-ийн
Хөнгөн
үйлдвэрлэлийн
технологи
инженерчлэлийн
салбарын дэд
профессор**



**Банзрагчийн
НАНДИН-ЭРДЭНЭ**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

/Эрсдэл, аудитын
хорооны дарга/

**СЭЗИС, Бизнесийн
Удирдлагын
тэнхимийн ахлах
багш**



**Такэши
КАМБЭ**

ТУЗ-ийн хараат бус
гишүүн

/Цалин урамшууллын
хорооны гишүүн/

**Asahi Life Insurance
Менежер**

ЕРДИЙН ГИШҮҮД



**Цагаачийн
БААТАРСАЙХАН**

ТУЗ-ийн ердийн
гишүүн

/Нэр дэвшүүлэх
хорооны гишүүн/

**Таван Богд
Группийн
Ерөнхийлөгч,
Говь ХК-ийн
Гүйцэтгэх захирал**



**Дашдаваагийн
ХУЛАН**

ТУЗ-ийн ердийн
гишүүн

/Эрсдэл, аудитын
хорооны гишүүн/

**Таван Богд Группийн
Тэргүүн дэд
ерөнхийлөгч**



**Хидэо
САВАДА**

ТУЗ-ийн ердийн
гишүүн

**Н.И.С компанийн
Ерөнхийлөгч**



**Жавзандолгорын
ОЮУНЧИМЭГ**

ТУЗ-ийн ердийн
гишүүн

/Цалин урамшууллын
хорооны гишүүн/

**Таван Богд Групп,
Маркетингийн
газрын захирал**



КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД

ОВОГ НЭР АЛБАН ТУШААЛ	АЖЛЫН ТУРШЛАГА
 <p>Цагаачийн БААТАРСАЙХАН</p> <p>Гүйцэтгэх захирал</p>	<p>Алтай ХХК-д Орлогч захирал, Таван Богд Трейд ХХК, Жуулчин ХХК, МИАТ ХК-иудын Ерөнхий захирал, Палас зочид буудлын Гүйцэтгэх захирлын албан тушаалуудыг хашиж байсан.</p> <p>Таван Богд Группийн Ерөнхийлөгч, Хаан Банкны ТУЗ-ийн гишүүн, 2008 оны 8 сараас одоог хүртэл Говь ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.</p>
 <p>Нямжавын СҮРЭНРАГЧАА</p> <p>Дэд захирал</p>	<p>Таван Богд Трейд ХХК-д Төслийн мэргэжилтэн, Төслийн туслах менежерээр ажиллаж байсан.</p> <p>2015 оны 4 сараас Говь ХК-ийн Бизнес удирдлагын газрын захирал, мөн оны 11 сараас одоог хүртэл Дэд захирлаар томилогдон ажиллаж байна.</p>
 <p>Батчулууны АРИУНАА</p> <p>Гадаад худалдаа хариуцсан захирал</p>	<p>2009 оноос 2014 оны хооронд Говь ХК-д Гадаад худалдааны менежер, Гадаад худалдааны газрын захирлаар ажиллаж байсан.</p> <p>2018 оны 9 сараас одоог хүртэл Говь ХК-ийн Гадаад худалдаа хариуцсан захирлаар ажиллаж байна.</p>
 <p>Батмөнхийн АЛТАНБУЯН</p> <p>Дотоод худалдаа хариуцсан захирал</p>	<p>В&G компанид Харилцааны ажилтан, ВВВ Korea хүмүүнлэгийн байгууллага-д Гадаад харилцааны ажилтан, Ямянжу интернэйшнл компани-д Багшаар ажиллаж байсан.</p> <p>2016 оноос Говь ХК-д Гадаад худалдааны менежерээр ажиллаж байгаад 2019 оноос Дотоод худалдаа хариуцсан захирлаар дэвшин ажиллаж байна.</p>



**Ганболдын
СЭЛЭНГЭ**

Санхүү хариуцсан
захирал

Гермес Тэсүн ХХК-д Ерөнхий нягтлан бодогч, Хаан Палас ХХК-д Ахлах нягтлан бодогч, Таван Богд Групп-д Нягтлан бодогч, Ерөнхий нягтлан бодогчоор тус тус ажиллаж байсан.

2013 оноос одоог хүртэл Говь ХК-д Санхүү хариуцсан захирлаар ажиллаж байна.



**Батсуурийн
БОЛОРМАА**

Бүтээгдэхүүн
хөгжүүлэлт
хариуцсан захирал

Дархан Минж ХХК-д Дизайнерээр ажиллаж байсан.

2007 оноос Говь ХК-д Чанар шалгагч, 2008 оноос Дизайнер, загвар зохион бүтээгч, 2016 оноос одоог хүртэл Бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан захирлаар ажиллаж байна.



**Чулуунбатын
СОЛОНГО**

Хүний нөөц,
захиргаа
хариуцсан захирал

Алтандорнод Монгол ХХК-д Гадаад харилцааны менежер, Боловсон хүчин, Таван Богд Групп-д Гадаад худалдааны менежер, Борлуулалт хариуцсан ахлах менежерээр тус тус ажиллаж байсан.

2014 оноос одоог хүртэл Говь ХК-д Хүний нөөц, захиргаа хариуцсан захирлаар ажиллаж байна.



**Цогтбаярын
ЦАСЧИХЭР**

Хуулийн хэлтсийн
дарга

Хэнтий аймгийн Цагдаагийн газарт Мөрдөн байцаагч, Хан-Уул дүүргийн Цагдаагийн газарт Мөрдөн байцаагч, Жаст Ойл ХХК-д Хуулийн зөвлөх, Эм Си Эс ХХК-д Хуульчаар тус тус ажиллаж байсан.

2014 оноос Говь ХК-д Хуулийн зөвлөх, 2018 оноос Одоог хүртэл Хуулийн хэлтсийн даргаар ажиллаж байна





**Саруулын
БОЛОРМАА**

ТУЗ-ийн нарийн
бичгийн дарга

Мобиком ХХК-д Байгууллагын бизнесийн газарт мэргэжилтэн, Таван Богд ХХК-д Захирлын ажлын албаны менежерээр ажиллаж байсан.

2019 оноос Говь ХК-д ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ НЭР	ГОВЬ ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШСЭН БАЙДАЛ	
	ДАНГААРАА	НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДҮҮД
Д.ХУЛАН	12,247,300 ширхэг (1.57%)	ЭФ-СИ-АЙ ХХК 28.59% ТАВАН БОГД ТРЕЙД ХХК 21.64%
Ц.БААТАРСАЙХАН	50,000 ширхэг (0.01%)	
НИЙТ	51.80%	

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

2019 онд Тогтвортой хөгжлийн хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлж байна.



“МАЛЧНЫ ХОТНООС ДЭЛХИЙН БРЭНД”

“Говь”ХК болон “Европын сэргээн босголтын банк” –ны хамтарсан “Малчны хотноос дэлхийн брэнд” төсөл нь Монгол улсын хоёр аймгийн нутаг дэвсгэрт бэлчээрийн доройтлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, зэрлэг амьтныг хамгаалах тогтвортой хамтын ажиллагааг дэмжих зорилготой бөгөөд ноолуурын өртгийн сүлжээнд оролцогч талуудыг нэгтгэн зангидсан цогц хөтөлбөрөөр дамжуулан Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын “Дэлгэрэхийн улаан ямаа” хоршоо болон Баянхонгор аймгийн Шинэжинст сумын “Залаа жинст торгон сүрэг” хоршооны малчдын амьжиргааг дээшлүүлэх, ноолуурын тогтвортой аж ахуйг хөгжүүлэхийг зорьж байна.

2019 оны эхний хагас жилд “Малчны хотноос дэлхийн брэнд” төслийн нээлтийн үйл ажиллагааны хүрээнд төслийн талаар аймаг, сумын удирдлага, хоршоо болон сумын иргэдэд танилцуулах, төсөл хэрэгжүүлэх зарим малчны хотоор орж мал аж ахуйн нөхцөл байдалтай танилцах, 2018 онд хоёр хоршоонд явуулсан бэлчээр ашиглалт, мал аж ахуй хөтлөх, ноолуур бэлтгэх зохистой дадлын (стандартын) хөндлөнгийн үнэлгээний үр дүнг танилцуулах, сургалт чиглүүлэг хийх, 2019 оны төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэх үйл ажиллагаануудыг компаний тогтвортой хөгжлийн хүрээнд зохион байгууллаа.



ОЛОН УЛСЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ СТАНДАРТУУДЫГ НЭВТРҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ

Говь ХК-ийн хамт олон бид Дэлхийн стандартад нийцсэн чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэн байгаль орчинд ээлтэй компани болох зорилгоор:

1. Олон улсын чанарын удирдлагын тогтолцооны **ISO9001:2015**
2. Байгаль орчны удирдлагын тогтолцооны **ISO14001:2015**
3. ХЭМАБ удирдлагын тогтолцооны **ISO45001:2018**, **Олон Улсын Удирдлагын Тогтолцооны Стандарт**-уудыг хэрэгжүүлэх төслийн ажлаа 2019 оны 04-р сарын 05-ны өдөр албан ёсоор эхлүүлсэн.

Тус төслийн хүрээнд 4-р сараас эхлүүлэх ажлууд хийгдэж, нийт ажилтнуудад 3 удаагийн сургалт зохион байгуулж мэдээлэл хүргэсэн. 7 хоног бүр зөвлөхөөс сургалт авч, хийх ажлын даалгаврууд өгөгдөж, зөвлөхтэйгээ хамтран даалгаврууд дээр ажиллаж байна.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН

Говь ХК нь бүхий л үйл ажиллагаандаа нийгмийн хариуцлагаа ухамсарлан бизнесийн үйл ажиллагаагаа шударгаар явуулж, нийгмийн хариуцлагын өндөр жишиг баримталдаг.

Бид хууль, дүрмийг чандлан сахиулан байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж, хүрээлэн буй орчин болон нийгмийн сайн сайхан чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж ажиллахаас гадна ажилтнуудынхаа ая тухтай, аюулгүй, ажиллах орчинг бүрдүүлэн нийгмийн асуудалд нь анхаарч, сурч боловсрох нөхцөлөөр ханган ажилладаг.

2019 ОНД НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД



**МОНГОЛ-СОЛОНГОСЫН
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ**

**МОНГОЛ-СОЛОНГОСЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ОЮУТНУУДАД ГОВЬ ХК-Д АЖИЛЛАХ УРИЛГА
ГАРДУУЛЛАА**

Монгол-Солонгосын политехник коллежийн оюутнуудын төгсөлтийн баярт оролцож, Говь ХК-д ажиллах урилга нийт 13 оюутанд гардуулав.

PRODUCTION



**ҮЙЛДВЭР УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ОЮУТНУУДАД ГОВЬ ХК-Д АЖИЛЛАХ УРИЛГА
ГАРДУУЛЛАА**

Үйлдвэр Урлалын политехник коллежийн оюутнуудын төгсөлтийн баярт оролцож, Говь ХК-д ажиллах урилга нийт 29 оюутанд гардуулав.



**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН 10-р цогцолборт
Олон Улсын Хүүхдийн баярын бэлэг тараалаа.**

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Сувиллын цэцэрлэг яслийн 10-р цогцолборын хүүхдүүдэд Олон Улсын Хүүхдийн баярын өдрийг тохиолдуулан бэлэг тараав. Цаашид тус цэцэрлэг яслийн анги танхимын тохижилт, засварын ажлууд болон шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг ханган нийлүүлэхэд нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжин ажиллана.

“Говь” ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар-17062, Монгол Улс, Ш/Х 36/434

Утас: +976 7013-9977, Факс: +976 7014-3081

Имэйл: info@gobi.mn

